



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/46

Хужирт сум

Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүн, ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2 дахь заалт, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны “Мэргэжлийн ангийн дүрэм шинэчлэн батлах тухай” 75 дугаар тушаалын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Гамшгаас хамгаалах ерөнхий зориулалттай мэргэжлийн ангиудыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн байгуулсугай.

2. Гамшгаас хамгаалах сумын мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүн, ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлж, бүтэц зохион байгуулалт, гүйцэтгэх үүрэг чиглэлийг тодорхойлон, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Мэргэжлийн ангийн дарга, бие бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн “Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүн, ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулах тухай” А/53 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ